



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

“Ган зам даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ган зам даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Ган зам даатгал” ХХК /В.Отгондэмбэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

00069

2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
33 тоот тогтоолын хавсралт



“ГАН ЗАМ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр /регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь	Хувь цааны тоо	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь
1	“Улаанбаатар төмөр зам” ХНН /2810913/	1,000	4,250,000	4,250,000,000	100%	750,000	750,000,000	5,000,000	5,000,000,000	100%
НИЙТ			4,250,000	4,250,000,000	100%	750,000	750,000,000	5,000,000	5,000,000,000	100%